

3

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦООНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ: СУДАЛГААНЫ, ҮР ДҮН

Н.Тунгалаг, Л.Оюунцэцэг, А.Еркеш

Абстракт: Монгол улс хуваарилалтын хэлбэртэй цалингаас болон шимтгэлээс тооцох тэтгэврийн тогтолцоотой. Хөгжүүлэлт, шинэчлэлт хийгдсээр ирсэн боловч шилжилтийн энэ үед тулгамдаад байгаа зарим асуудлыг судалж мөн чанарыг нь тогтоох, цаашид засаж залруулан зөв гольдролд нь оруулж иргэдийн өтөл насны амьдралын баталгааг найдвартайгаар бий болгоход хувь нэмрээ оруулахад уг ажил чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: дундаж цалин, тэтгэврийн даатгал, нэрийн данс, тэтгэвэр, шимтгэл. Онолын талаас нь авч үзвэл иргэдийн тэтгэврийн даатгал хэд хэдэн хэлбэрээр хэрэгжиж болдог байна. Тэтгэврийн орлого бий болгох санхүүжилтын талаасаа: **Хуваарилалтын хэлбэр(PAYG):** Энэ нь даатгуулагчдаас шимтгэл хураан авч тухайн үед тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэвэрт шууд зарцуулах замаар залуу үеийнхний шимтгэлийн орлогоор ахмад үеийнхний тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх арга юм. Энэ аргыг хэрэглэх үед даатгалын санд хөрөнгө төдийлэн хуримтлагдахгүй. Манай иргэдийн тэтгэврийн систем бүхэлдээ энэ хэлбэрт хамаарч байна.

Бүрэн хуримтлалын хэлбэр(Full Funding): Энэ нь үе үеийн иргэд тэтгэвэрт гарахаасаа өмнө урьдчилж хөрөнгө хуримтлуулах санхүүгийн арга бөгөөд хуримтлагдсан хөрөнгийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсний дараа тэтгэврийн орлогын эх үүсвэр болгон ашигладаг. Энэ бол тэтгэврийн “бүрэн хуримтлал”-ын тогтолцоо бөгөөд хуримтлалын хэмжээ нь тэтгэвэрт зарцуулах хөрөнгөтэй тэнцүү буюу түүнээс их байна.

Хагас хуримтлалын хэлбэр(Partial Funding): Энэ нь хуваарилалтын болон хуримтлалын тогтолцооны хосолсон санхүүжилтийн арга юм. Хагас хуримтлалын тогтолцоо хэрэгжих нөхцөлд тодорхой хэмжээний хөрөнгө хуримтлуулж болно, гэхдээ хуримтлал нь олгож байгаа тэтгэвэрт зарцуулах хөрөнгөний хэмжээнээс бага байна. Өөрөөр хэлбэл, зарцуулбал зохих хөрөнгийн

зарим хэсэг нь шимтгэлээр хуримтлагдаж байхад зарим хэсгийг нь улсын төсвөөс санхүүжүүлнэ гэсэн үг болно. Тэтгэвэр тогтоолт, зарцуулалтын талаасаа:

Цалингаас тооцох тэтгэврийн тогтолцоо (Defined Benefit (DB) System): Энэхүү тогтолцооны хүрээнд даатгуулагчийн тэтгэвэр түүний цалингийн хувь хэмжээгээр тодорхойлогдоно. Үндсэндээ, тэтгэвэр бол тухайн даатгуулагчийн цалингийн функц юм. Цалингаас тооцох тэтгэврийг хуваарилалт, хуримтлал ба хагас хуримтлалын зарчмаар санхүүжүүлж болно. 1960 оноос өмнө төрсөн иргэдийн тэтгэвэр энэ тогтолцооны дагуу тогтоогдож байна.

Шимтгэлээс тооцох тэтгэврийн тогтолцоо (Defined Contribution (DC) System): Энэ бол даатгуулагч бүрийн шимтгэлийг түүний хөрөнгө оруулалтын нэрийн дансанд байршуулах тэтгэврийн тогтолцоо юм. Тухайн иргэн тэтгэвэр тогтоолгох үед тэтгэврийг нь санхүүжүүлэхийн тулд дансны хөрөнгийг нь ашиглана. Шимтгэлээс тооцох тэтгэврийн тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоо хэмээн тодорхойлдог.

Шимтгэлээс хийсвэр тооцох тогтолцоо (Notional Defined Contribution (NDC) System): Хуваарилалтын зарчмаар санхүүжих нэрийн дансны тогтолцоо. Шимтгэлээс хийсвэр тооцох тогтолцоо нь шимтгэлээс тооцох тогтолцоотой олон талаар төсөөтэй. Гэхдээ, шимтгэлээс хийсвэр тооцох дансанд бодит хөрөнгө хуримтлагдахгүй, шимтгэлээс хийсвэр тооцох данс бол тухайн иргэний тэтгэврийн эрхийг тодорхойлох бүртгэл тооцооны арга юм. 1960 оноос хойш төрсөн иргэдийн тэтгэвэр энэ тогтолцооны дагуу тогтоогдохоор байна.

Дээрхээс үзэхэд манай тэтгэврийн даатгалын тогтолцоо хуваарилалтын хэлбэртэй, цалингаас болон шимтгэлээс (хийсвэр) тооцох тогтолцоотой болох нь харагдаж байна. Бид бүрэн хуримтлалын хэлбэртэй, шимтгэлээс тооцох тогтолцоотой тэтгэврийн даатгалын нэрийн дансны өнөөгийн байдал, цаашдын төлөвд судалгаа хийж зарим саналыг дэвшүүлж байгаа болно.

Энд дундаж цалинг хоёр хувилбараар тооцсон бөгөөд эхнийх нь албан ёсны улсын дунджийг 2030 он хүртэл прогнозчилон нэрийн дансанд орох шимтгэл, тооцогдох хүү, хуримтлагдах санг нэг хүнийхээр тооцож дүгнэлт өгсөн. Үүнд:

Дундаж цалингийн хэтийн тооцоо

Он	жилийн код, i	Экспоненциал загвараар	Логистик загвараар	Дундаж хувилбараар тооцсон дундаж цалин, ₮
		r = 0.072282	K=0.00000 01620	
2007	1	155280	155280	155280
2010	4	192881	249504	226855
2015	9	276853	483208	400666
2020	14	397381	756830	613051
2025	19	570382	968513	809260
2030	24	818699	1085723	978914

Дундаж цалинг шимтгэл төлөх суурь болгон дараахь 5 хувилбараар тооцоолол хийсэн.

1. Нэрийн дансны үлдэгдэлд өнөөдөр тооцож буй Засгийн Газрын хүүгийн түвшинг харгалзан тэтгэврийн эрх нээгдэх өдрөөрх үлдэгдлийг тооцоолон түүнийг хуулийн дагуу хуваарилах. Энэ тооцоонд ЗГ-ын санал болгож байгаа жилийн 1.15 хувийн хүүг нэрийн дансанд орлого оруулж байх хугацаанд тооцож харин орлого орохгүй буюу тэтгэвэрт гарсанаас хойш хүү тооцохгүйгээр хуримтлагдсан шимтгэлийг тэтгэвэр авах дундаж хугацаанд харьцуулан тооцоолсон. Энэ үед 1960 онд төрж дундаж цалингаар 2020 он хүртэл цалинжсан даатгуулагч 2035 он дуустал 16 жилийн турш сарын 78728 төгрөгийн тэтгэвэр сард авах тооцоо гарч байна.

2. Нэрийн дансны үлдэгдэлд төлж байгаа Засгийн Газрын хүүгийн түвшинг харгалзан тэтгэврийн эрх нээгдэх өдрөөрх үлдэгдлийг тооцоолон түүнийг хуулийн дагуу хуваарилахдаа нэрийн дансанд орлого ороогүй байх үед ч ЗГ-ын санал болгож байгаа хүүгээр жил тутмын үлдэгдэлд нь хүү тооцох. Энэ тооцоонд ЗГ-ын санал болгож байгаа жилийн 1.15 хувийн хүүг нэрийн дансанд орлого оруулж байх хугацаанд болон тэтгэвэрт гарсанаас хойшхи хугацаанд нэрийн дансны үлдэгдэлд тооцож хуримтлагдсан дүнг тэтгэвэр авах дундаж хугацаанд харьцуулан тооцоолсон. Энэ үед 1960 онд төрж дундаж цалингаар 2020 он хүртэл цалинжсан даатгуулагч 2035 он дуустал 16 жилийн турш дунджаар сарын 78728 - 93458 төгрөгийн тэтгэвэр авахаар болж байна. Энэ үед дундаж цалин 613051 - 1175120 төгрөг болсон байхаар тооцогдож байгаа учир энэ хэмжээний тэтгэвэр нь тэр үеийн 1960 оноос өмнө төрсөн хүмүүсийн тэтгэврийн хэмжээнээс ихээхэн доогуур гарахаар харагдаж байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээний дундаж цалингаас 1960 оноос өмнө төрсөн хүмүүст тэтгэвэр тооцож байгаа аргачлалаар 275873 төгрөгийн тэтгэвэр тогтоогдохоор тооцоо гарч байна.

3. Нэрийн дансны үлдэгдлийг зах зээлийн хүүгээр өсгөж тэтгэвэрийн эрх нээгдэх өдрөөр хуулийн дагуу хуваарилах. Энэ тооцоонд санхүүгийн зах зээлийн өнөөгийн хүүг жилийн 15.6-8.0 (2007-2011 онд 15.6%, 2012-2016 онд 13.2%, 2017-2025 онд 10.8%, 2026 оноос тооцоог дуусталх хугацаанд 8%) хувийн хүүг нэрийн дансанд орлого оруулж байх хугацаанд тооцож харин орлого орохгүй байх хугацаанд хүү тооцохгүйгээр хуримтлагдсан шимтгэлийг тэтгэвэр авах дундаж хугацаанд харьцуулан тооцоолсон. Энэ үед 1960 онд төрж дундаж цалингаар 2020 он хүртэл цалинжсан даатгуулагч 2035 он дуустал 16 жилийн турш сарын 204681 төгрөгийн тэтгэвэр авахаар болж байна. Энэ хэмжээ нь тухайн үеийн дундаж цалингийн 33.4 хувьтай тэнцүү байгаа нь мөн өнөөгийн тооцогдож байгаа түвшинтэй дүйцэх боломжгүй байгаа нь харагдаж байна.

4. Нэрийн дансны үлдэгдлийг зах зээлийн хүүгийн түвшинг харгалзан өсгөж тэтгэвэрийн эрх нээгдэх өдрөөрх үлдэгдлийг тооцоолон түүнийг хуулийн дагуу хуваарилахдаа нэрийн дансанд орлого ороогүй байх үед ч зах зээлийн хүүгийн түвшинг харгалзан хүү тооцогдох. Энэ тооцоонд санхүүгийн зах зээл дээрх 3-д авсан хүүг нэрийн дансанд орлого

оруулж байх хугацаанд болон тэтгэвэрт гарснаас хойшхи хугацаанд нэрийн дансны үлдэгдэлд тооцож хуримтлагдсан дүнг тэтгэвэр авах дундаж хугацаанд харьцуулан тооцоолсон. Энэ үед 1960 онд төрж 2020 он хүртэл дундаж цалингаар цалинжсан даатгуулагч 2035 он дуустал 16 жилийн турш дунджаар сарын 443612 төгрөгийн тэтгэвэр авахаар болж байна. Энэ үед тэтгэврийн хэмжээ жил бүр 11-8 хувиар өсөх боломжтой болж 204681 төгрөгөөр тогтоогдож байсан тэтгэвэр 10 жилийн дараа 515243 төгрөг, 16 жилийн дараа 757 061 төгрөг болж өссөн нь дундаж цалингийн өсөлтөөс хоцрохгүй байх боломжтой болох юм гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл тэтгэврийн хэмжээг дундаж цалинтай харьцуулж үзвэл 2030 онд дундаж цалингийн 53 хувь, 2035 онд 66 хувь болж байна.

5. Нэрийн дансны үлдэгдлийг зах зээлийн хүүгийн түвшинг харгалзан өсгөж тэтгэврийн эрх нээгдэх өдрөөрх үлдэгдлийг тооцоолон түүнийг хуулийн дагуу хуваарилахдаа нэрийн дансанд орлого ороогүй байх үед ч ЗГ-ын санал болгож байгаа хүүгээр хүү тооцогдох. Энэ тооцоонд нэрийн дансанд орлого оруулж байх хугацаанд санхүүгийн зах зээл дээрх хугацаатай хадгаламжийн хүүг, өөрөөр хэлбэл 15.6-8.0 хувийн хүүг, нэрийн дансанд орлого оруулахаа больсон хугацаанд нэрийн дансны үлдэгдэлд ЗГ-ын санал болгож байгаа хүү болох 1.15 хувийн хүүг тооцож хуримтлагдсан дүнг тэтгэвэр авах дундаж хугацаанд харьцуулан тооцоолсон. Энэ үед 1960 онд төрж дундаж цалингаар 2020 он хүртэл цалинжсан даатгуулагч 2035 он дуустал 16 жилийн турш дунджаар сарын 223319 төгрөгийн тэтгэвэр авахаар болж байна. Энэ нь хэдийгээр эхний 3 хувилбартай харьцуулахад дэвшилттэй боловч өнөөдрийн хуулийн дагуухь дундаж цалингийн 45 хувьтай харьцуулахад бага болох нь харагдаж байна.

Тэтгэврийн доод хэмжээ. Тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үеийн дундаж цалингийн 20 хувиас багагүй байна гэж хуульд заасны дагуу төлөвлөсөн цалингийн дундаж хэмжээнээс тооцож үзвэл:

Он	Дундаж цалин, төгрөг	Сарын тэтгэврийн доод хэмжээ(ДЦ-ийн 20%), төгрөг
2020	613 051	122 610
2025	809 260	161 852
2030	978 914	195 783
2035	1 153 403	230 681

Хөдөлмөрлөх бүх хугацаандаа дундаж цалингаар цалинжиж байсан нэг хүний хувьд 1930 онд авах тэтгэврийн хэмжээг дээрх хувилбар тус бүрээр авч үзвэл:

Хувилбар	Тооцоолсон тэтгэврийн хэмжээ, төгрөг	Дундаж цалингийн хувиар
Хувилбар 1	78 728	8,0
Хувилбар 2	88 265	9,0
Хувилбар 3	204 681	20,9
Хувилбар 4	515 243	52,6
Хувилбар 5	229 476	23,4

Эндээс 1, 2-р хувилбар тэтгэврийн доод хэмжээний талд нь ч хүрэхгүй, 3 ба 5-р хувилбарууд нь тэтгэврийн доод хэмжээг дөнгөж ханган, 4-р

хувилбар нь боломжийн байгаа бөгөөд энэ нь нэрийн дансны үлдэгдэлд зах зээлийн дээд жишгээр хүү бодож өсгөсөн хувилбар юм. Эндээс нэрийн дансны үлдэгдэлд зах зээлийн жишгээр хүү тооцон өсгөхгүйгээр тухайн үеийн тэтгэврийн хэмжээ нь дундаж цалингийн өсөлтийг гүйцэхгүйгээр барахгүй тэтгэврийн доод хэмжээг ч хангаж чадахгүй болох нь тооцооноос харагдаж байна.

ОН	Дундаж цалин	ОН	Дундаж цалин	ОН	Дундаж цалин	ОН	Дундаж цалин	ОН	Дундаж цалин	ОН	Дундаж цалин
2001	29253	2006	88880	2011	120639	2016	163417	2021	217439	2026	280027
2005	43685	2010	113455	2015	153930	2020	205821	2025	267038	2030	333179

Хоёрт, дээрх 5 хувилбараарх тооцооллыг 2000-2005 онд Нийгмийн даатгалын байгууллагад шимтгэл тооцож төлсөн цалингийн дундажид үндэслэн хийж үзлээ. Тооцооллоос өнөөгийн шимтгэл төлж буй дундаж цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ч хүрдэггүй болохыг харж болно. Гэтэл энд төсвийн байгууллагын ажиллагсдын цалин орж байгаа бөгөөд тэд олгохоор тооцоолсон цалингийн дүнгээс хуулийн дагуу бүх шимтгэлээ төлдөг билээ. Эндээс хувийн хэвшил болон бусад аж ахуйн нэгж байгууллагууд шимтгэл төлөх цалингаа амьдралаас хол, хэт доогуур мэдээлж, тэр дүнгээсээ тэтгэврийн даатгалын шимтгэл тооцож төлдөг, үүнийг нийгмийн даатгалын байцаагчид хянаж чаддаггүй болох нь харагдаж байна.

Хэрвээ ийм байдлаар даатгалын шимтгэл хуримтлагдаж, ЗГ-аас шимтгэлийн орлогыг төсөвт татан оруулж 1,15 хувийн хүү хийсвэрээр тооцоод явбал 2020 он гэхэд анхны тэтгэвэрт гарч буй хүний доод тэтгэвэр 36748 төгрөг, байхаар тооцоо гарч байна.

Өнөөгийн шимтгэл төлж буй цалингаар тооцсон тэтгэврийн сангийн хуримтлал

Хувилбар	Сард олгох тэтгэврийн хэмжээ, □
Хувилбар 1: Өнөөгийн хүү, хуулийн дагуу тэтгэвэрт гартал үлдэгдэлд хүү тооцох	36 748
Хувилбар 2: Өнөөгийн хуулийн дагуу, гэхдээ үлдэгдэл 0 болтол хүү тооцох	41 200
Хувилбар 3: Үлдэгдэлд зах зээлийн жишгээр тэтгэвэрт гартал хүү тооцох	111 600
Хувилбар 4: Үлдэгдэлд зах зээлийн жишгээр 0 болтол хүү тооцох	281 000
Хувилбар 5: Тэтгэвэрт гартал нь зах зээлийн жишгээр, тэтгэвэрт гарснаас хойш 1,15% хүү тооцох	125 000

Дүгнэлт, санал:

• Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тогтолцоо нь Монгол Улсын тэтгэврийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талруу үйлчилсэн дэвшилтэт систем төдийгүй даатгуулагчид хөдөлмөрийн чадвартай байх хугацаандаа хуримтлуулсан шимтгэлээс тооцон тэтгэвэр авах нь зах зээлийн зарчимд нийцсэн дэвшилтэт арга болсон гэж дүгнэж байна.

• Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тогтолцоо хуулиараа бүрэн хуримтлалын хэлбэртэй юу эсвэл хуваарилалтын хэлбэртэй юу гэдэг нь тодорхойгүй байгаа бөгөөд хэрэв бүрэн хуримтлалын тогтолцоо гэж үзвэл бодит хөрөнгө дансанд хуримтлагдсан байх ёстой бөгөөд тэтгэврийг энэ хөрөнгөөр санхүүжүүлэн олгох ёстой. Өнөөг хүртэл нэрийн дансанд ямарч хөрөнгө хуримтлагдаагүй гэдэг нь ойлгомжтой. Хуваарилалтын хэлбэртэй шимтгэлээс хийсвэр тооцох тэтгэврийн тогтолцоо гэвэл нэрийн дансанд хуримтлагдан хийсвэрээр тооцогдсон дүнг тэтгэвэр тогтооход тооцооллын хэрэглүүр болгон ашиглах ёстой болохоор хожим хуулийн дагуу хүмүүсийн тэтгэврийг тооцон олгоход дээрх 5 хувилбараар тооцсон үр дагавар үүсэж болно гэдгийг онцгой анхаарах ёстой.

• Тэтгэврийн даатгалд хамрагдан шимтгэл төлж буй цалингийн дундаж хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хангахтай үгүйтэй байгааг анхаарч, Нийгмийн даатгалын байгууллагын зүгээс шимтгэл тооцолт, төлөлтөнд хяналт тавин ажиллах шаардлагатай мэт санагдлаа. Энд даатгуулагчдад хандсан сургалт сурталчилгааны ажил ч шаардлагатай бөгөөд манай даатгуулагчид өнөөгийн шимтгэл төлөлт тэдний ирээдүйн баталгаа гэдгийг тэр бүр ойлгохгүйгээс ажил олгогчид тэдэнд олгодог хөдөлмөрийн хөлсийг дутуу мэдээлж, бага цалингаас шимтгэл төлдөг байж болзошгүй дүр зураг харагдаж байна. Үүнтэй холбоотойгоор амьжиргааны баталгаажих доод түвшин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дорвитой нэмэгдүүлэх шаардлагатай байж болно.

• Нэрийн дансны үлдэгдэлд тооцож байгаа хүүгийн хэмжээ хэт доогуур 1.15 хувь байгаа нь 2020 оноос тэтгэврийн нэрийн дансны үлдэгдлийг ашиглан тэтгэвэр тооцон олгож эхлэхэд тэр нь тэтгэврийн доод хэмжээ болон амьжиргааны баталгаажих доод түвшинг хангаж чадахгүй байх эрсдэлтэй байна. Иймээс нэрийн дансны үлдэгдэлд тооцож байгаа хүүгийн хэмжээг өсгөж зах зээлийн хүүгийн түвшинд хүргэх шаардлагатай. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” Монгол Улсын хуулийн 6.3-д зааснаар “. . . нэрийн дансанд тооцох хүү, нийгмийн даатгалын шимтгэл төлөх дундаж хөдөлмөрийн хөлсний өсөлтийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэсний дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл үүнд онцгой анхаарах шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” МУ хууль, 1999
2. Н.Тунгалаг, Р.Энхбат, “Насжилт ба тэтгэврийн тогтолцоо, судалгааны ажлын тайлан”, УБ, 2000
3. Ch.Dagvadorj, R.Enkhbat. Some Macroeconomic Indicator on Pension System in Mongolia, Proceedings of the Mongolian Academy of Sciences, Vol.152, No.2, pp.38-51, 1999. (in Mongolian)
4. Ч.Дагвадорж, Нийгмийн хамгаалал: онол арга зүй, туршлага, харьцуулалт, УБ., 2004
5. “Монголын хүн амын сэтгүүл” дугаар 14, 2006
6. Е.М.Четыркин “Финансовая математика” Москва 2000г
7. Robert Holzmann, Edward Palmer “Pension Reform” The World Bank, Washington, D.C., 2006
8. Stephen P.Shao “Mathematics for Management and Finance”, 1998
9. Н.Тунгалаг, Р.Энхбат, Л.Оюунцэцэг, А.Еркеш, “Тэтгэврийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, даатгалын тогтолцоог шинэчлэх” судалгааны тайлан, УБ., 2006